



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 104

Бат-Өлзий сум

Шууд худалдан авах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг, Засгийн газрын "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоол, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "2024 оны төсөв батлах тухай" 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 18/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бат-Өлзий сумын Засаг даргын Тамгын газар, Багийн захиргааны албан хэрэгцээний шатахуун, шатах тослох материал нийлүүлэх ажлыг ажлын хэсгийн 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн хурлын зөвлөмж дүгнэлтийг үндэслэн "Оргил гүүр" хязгаарлагдмал хариуцлагатай компанитай шууд худалдан авах гэрээ байгуулан гүйцэтгүүлсүгэй.

2. "Оргил гүүр" хязгаарлагдмал хариуцлагатай компанитай гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн (Э.Дашдулам)-д даалгасугай.

3. Засаг даргын Тамгын газрын шатахуун, шатах тослох материал нийлүүлэх зардалд шаардагдах 18,898,600 (арван найман сая найман зуун ерэн найм зургаан зуу) төгрөг, Багийн захиргааны шатахуун, шатах тослох материал нийлүүлэх зардалд шаардагдах 4,338,000 (дөрвөн сая гурван зуун гучин найман мянга) төгрөг, нийт зардалд шаардагдах 23,236,600 (хорин гурван сая хоёр зуун гучин зургаан мянга зургаан зуу) төгрөгийг гэрээнд заасан хугацааны дагуу санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.



ДАРГА

Н.БАТ-ЭРДЭНЭ